

Гепатит В гэж юу вэ?

Гепатит В бол элэг рүү халддаг вирус юм. Хэрэв эмчлүүлэхгүй орхивол элэгний дутагдал, хорт хавдарт хүргэдэг.

Дэлхий даяар ойролцоогоор 296 сая хүн гепатит В-тэй амьдарч байна. Олон хүн өвдөж мэдрэгдэх эсвэл харагддаггүй тул халдвар авсан гэдгээ мэддэггүй.

Гепатит В нь хүнээс хүнд халдвартай цус эсвэл биеийн тодорхой биеийн шингэнээр дамжин тархдаг.

Гепатит В ба жирэмслэлт

Хэрэв та жирэмсэн бол жирэмсний хяналтын нэг хэсэг болох гепатит В-ийн цусны шинжилгээг өгөх ёстой.

Хэрэв та халдвартай бол гепатит В-г шинээр төрсөн хүүхэддээ төрөх явцдаа халдааж болзошгүй.

Хэрэв та жирэмсэн, гепатит В-тэй бол хүүхдэд тань халдварлахаас сэргийлж багц тарилгыг төрөх үеэс эхлэн хийлгэж болно.



Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

Centers for Disease Control and Prevention (CDC/ӨХУСТ, Өвчний Хяналт, Урьдчилан Сэргийлэлтийн Төвүүд)
www.cdc.gov/hepatitis/hbv/

Гепатит В-тэй Ээжүүд
www.hepbmoms.org (Англи хэл дээр)



DOH 420-406 May 2022 Mongolian
Энэ баримт бичгийг өөр форматаар авах бол 1-800-525-0127 руу залгана уу. Дүлий эсвэл сонсголын бэрхшээлтэй үйлчлүүлэгчид, 711 (Washington Relay) руу залгана уу эсвэл civil.rights@doh.wa.gov руу э-мэйл бичнэ үү.
Эх сурвалж: CDC, Protect Your Baby for Life

**Гепатит В:
Та өөрийгөө
болон хүүхдээ
хамгаалахын
тулд юу мэдэх
хэрэгтэй вэ**





Хүүхдээ хамгаалж, гепатит В-с сэргийлээрэй

Хүүхэд тань төрснөөс хойш 24 цагийн дотор анхны гепатит В-ийн вакциныг хийлгэх ёстой.

Хэрэв та гепатит В-тэй бол, хүүхэд тань төрөөд 12 цагийн дотор гепатит В-ийн дархлааны глобулиныг (HBIG) хийлгэх ёстой байдаг.

Хүүхдэд тань гепатит В-ийн бүх 3 вакцин, гепатит В-с хамгаалах HBIG тарилга хэрэгтэй. Хамгаалагдсан эсэхийг баталгаажуулахын тулд хүүхдээ 9-12 сартайд шинжилгээ өгөөрэй.

Хийлгэх хугацаа	Гепатит В-тэй жирэмсэн хүнээс төрсөн нялх хүүхдийн хувьд
Төрөөд	Гепатит В-ийн вакцин болон дархлааны глобулины (HBIG) төрөлтийн тунг хийлгэнэ
1-2 сартайд	Гепатит В-ийн вакцины 2-р тунг хийлгэнэ
6 сартайд	Гепатит В-ийн вакцины 3-р тунг хийлгэнэ
9-12 сартайд	Хүүхэд тань хамгаалагдсан гэдгийг баталгаажуулах шинжилгээ өгнө

Хүүхдээ хамгаалах өөр ага замууд:

- Хэрэв та гепатит В-тэй бол хүүхдээ хөхөөр хооллож болно. Хөхний толгой тань хагарч, цус гарвал эмчтэйгээ ярилцаарай, үргэлжлүүлэн хөхөөр хооллоход тань туслах сонголтууд бий.
- Гепатит В-ийн вакцинаа бүртгүүлж, эмнэлэгт очихдоо өөртөө авч очно уу.
- Гэр бүлийн гишүүдээ гепатит В-ийн шинжилгээ өгүүлж, вакцин хийлгээрэй.

Хэрэв та гепатит В-гүй бол

Аюулгүй бөгөөд үр дүнтэй вакцинаар та өөрийгөө болон хүүхдээ хамгаалж чадна. Цувралыг заавар дуусгаарай!

Хийлгэх хугацаа	Нялх хүүхийн хувьд
Төрөөд	Гепатит В-ийн вакцины төрөлтийн тунг хийлгэнэ
1-2 сартайд	Гепатит В-ийн вакцины 2-р тунг хийлгэнэ
6 сартайд	Гепатит В-ийн вакцины 3-р тунг хийлгэнэ

Хэрэв та гепатит В-тэй бол өөртөө анхаарал тавиарай

Та элэгнийхээ эрүүл мэндийг шалгахын тулд нэмэлт шинжилгээ өгч, эмчилгээ хэрэгтэй эсэхээ мэдэж болно.

Вирусын эсрэг гэж нэрлэгддэг эмүүд нь гепатит В-тэй олон хүнийг эмчлэх боломжтой. Гэсэн хэдий ч хүн бүр эмчилгээ хийлгэх шаардлагагүй.

Зарим эм элгийг гэмтээж болзошгүй тул жороор олгодог, жоргүй олгодог эм, нэмэлт тэжээл, витамин хэрэглэхээсээ өмнө эмчээс асуугаарай.

Мөн танд гепатит А-ийн вакцин тустай байж болно. Халдвараа хянахын тулд төрснийхөө дараа эмчтэйгээ үргэлжлүүлэн уулзаарай.

Гепатит В миний хүүхдийн хувьд аюултай юу?

Хүүхдүүд гепатит В-р халдварласнаар насан туршийн, архаг халдвартай болох магадлал 90% байдаг.

Эмчлээгүй орхивол, архаг гепатит В-тэй 4 хүүхэд тутмын 1 нь элэгний гэмтэл, элэгний өвчин эсвэл элэгний хавдар зэрэг ноцтой элэгний асуудалтай болдог.

Азаар, гепатит В-ийн халдвараас маш аюулгүй бөгөөд үр днтэй вакцины тусламжтай сэргийлж болно.